

7

**МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ
ТУЛГАМДСАН АСУУДЛУУД****Э. Гүргэмжав**

Монгол улсад үндэсний худалдаа байгуулагдсанаас хойш 80 жилийн нүүрийг үзжээ. Энэ түүхэн хугацаанд бидний өмнөх ба өнөө үеийнхний хүч хөдөлмөрөөр үндэсний мөнгөн тэмдэгт бий болгосон, үндэстний банк байгуулсан, гадаад худалдаанд онц эрх тогтоосон, худалдааг таван жилийн төлөвлөгөөгөөр хөгжүүлсэн, социалист эдийн засгийн интеграцид нэгдэн орсон, зах зээлийн харилцаанд шилжин орж гадаад худалдааг либералчлах ажлыг эхэлсэн гээд олон зүйл хийснийг хэн ч үгүйсгэхгүй. Харин түүхт энэ хугацаанд монгол улс зах зээлийн төгтолцоонд шилжих үе хүртэл гадаад худалдаа хөгжлийн ямар түвшинд хүрснийг дараах хэдэн баримтаар нотлож болох билээ.

Судалгаанаас үзэхэд 1989 оны байдлаар гадаад худалдааны нийт эргэлтийн 95% нь ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудтай хийгдэж байсан ба үлдэх хувь нь бусад орнуудад ногдож байв. 1989 он гэхэд Монгол орон өөрийн хэрэгцээт үйлдвэрлэлийн хэрэгслийн 90 хувь, өргөн хэрэглээний барааны 40 хувийг ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудаас авч байв.

Шинжилгээнээс үзэхэд Монголын экспорт дээд цэгтээ хүрч байсан 1989 онд 721.5 сая ам долларын экспортоос зөвхөн 6.5 хувь нь зах зээлийн орнууд руу гарч байжээ. Нийт экспортын 90 гаруй хувь Орос болон ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудад ногдож байв.

Мөн 1989 онд нийт экспортод хүнсний биш түүхий эд, дахин боловсруулах бүтээгдэхүүн 30.9 хувь, түүхий эд металл, химийн бүтээгдэхүүн 26.8 хувь, хүнсний үйлдвэрийн түүхий эд 13.4 орчим хувийг эзлэж байсан юм. Экспортын дийлэнхийг нь уул уурхайн болон мал аж ахуйн гэрэлтэй түүхий эд эзлэж байв.

Импортын 33%-ийг машин тоног төхөөрөмж, 25%-ийг түлш шатахуун, хэрэглээний бараа 20.9%-ийг тус тус эзлэж байлаа.

1921-1990 он хүртэлх гадаад худалдааны хөгжлийг судлаад бид дараах дүгнэлтэд хүрч байна.

Үүнд:

- Монгол улсын гадаад худалдаа 1921-1990 он хүртэл хөгжил дэвшлийн чухал түүхэн үеийг туулжээ. Гадаад худалдааны нийт эргэлт, импорт тасралтгүй өссөн байна.
- ОХУ болон ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудтай хийсэн худалдаа нийт гүйлгээний 90 орчим хувийг эзлэж байв. Энэ нь тухайн үеийн улс төр, эдийн засгийн системтэй шууд холбоотой гэж дүгнэв.
- Экспортын зонхилох хувийг уул уурхайн болон мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн эзлэж байсан нь Монгол улсын эдийн засгийн хөгжил бүтцийн илэрхийлэл юм.
- Гадаад худалдааг таван жилийн төлөвлөгөөгөөр хөгжүүлж тодорхой үр дүнд хүрсэн нь энэ үеийн хөгжлийн онцлог шинж байжээ.
- ЭЗХТЗ-ийн гишүүнд элссэн нь худалдааг эрчимжүүлэх, ялангуяа экспортын чиглэлийн үйлдвэрийг хөгжүүлэхэд аятай боломж бий болгожээ.
- Гадаад худалдаанд улсын онц эрх тогтоож, дээрээс төлөвлөн удирдах систем ноёрхож байсан нь худалдааны хөгжилд эерэг, сөрөг нөлөө үзүүлжээ.

Эдийн засаг нь баян чинээлэг, тогтвортой, хөгжиж дэвшдэг байх явдал нь аливаа улс орны Засгийн газруудын өмнө нь тавигддаг нийтлэг зорилт юм.

Тэгвэл эдийн засгийн гадаад харилцаагаар дамжуулан улс орнууд орлого олж, түүний тусламжтайгаар эдийн засгийн тогтвортой байдлаа хангаж, хөгжил дэвшлээ түргэтгэх нэгэн чухал зорилтыг дэвшүүлэн тавьдаг.

Монгол улс нэгэнт зах зээлийн тогтолцоог сонгон авсан болохоор эдийн засгийн харилцааг нээлттэй болгон үйл ажиллагааг либералчлах нь зайлшгүй болсон билээ. Үүний тулд 1990 оноос хойш дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн ажээ. Үүнд:

1. Гадаад харилцааг либералчлах, өмчийн тогтолцоог өөрчлөх орчин бүрдүүлэх арга хэмжээ болох улсын үйлдвэрүүдийг (88%) хөрөнгө оруулалтын тасалбараар хувьчилж худалдаа нийтийн хоолны газрыг (90%) хувийн өмчид шилжүүлсэн.
2. Эдийн засгийн гадаад харилцааг либералчлах эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор хуучин мөрдөгдөж байсан хууль тогтоомжуудыг зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд нийцүүлэн өөрчилсөн.
3. Монгол улсыг дэлхийн эдийн засгийн гол байгууллагуудад элсүүлэх замаар эдийн засгийн гадаад харилцааг хөгжүүлэх, гадаад орчны нөлөөллийг таатай болгох арга хэмжээг авч явуулж чадав (ДХБ, ДБанк, ОУВС, АХБ зэрэг байгууллагад нэгдэв).
4. Эдийн засгийн гадаад харилцааг либералчлах гол хэрэгсэл болох тарифын горимыг бүхэлд нь өөрчлөн, олон талт худалдааны системд мөрдөгдөх боломж бүхий тарифын системийг шинэчлэн сайжруулж чадсан юм.
5. Үнэ, ханшийг чөлөөлөх дэс дараалсан арга хэмжээг (1991-1999 он хүртэл) авч хэрэгжүүлсэн.

Эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлснээр эдийн засгийн гадаад харилцаа либералчлагдаж, дараах өөрчлөлтүүд гарсан гэж ойлгож болох талтай.

Хүснэгт №1-ээс үзэхэд эдийн засгийн хөгжлийн гол индикатор болох ДНБ-ний хэмжээ өсөх хандлагатай байгаа ба түүний өсөлтөд хөрөнгө оруулалт хүчтэй нөлөөлсөн байна. 1995-2000 онд нийт хөрөнгө оруулалтын өсөлтийн хурд ДНБ-нийхээс 4 дахин давж гарсан бөгөөд үүнийг эдийн засагт гарч буй нааштай өөрчлөлт гэхээс өөр аргагүй.

Монгол улсын макро эдийн засгийн болон гадаад худалдааны зарим үндсэн үзүүлэлтүүдийн бодит өсөлт 1995-2000 онд (1995 онтой зэрэгцүүлснээр)

Хүснэгт №1

Үзүүлэлтүүд	1995 он	2000 он	1995-2000 оны жилийн дундаж өсөлт
ДНБ	100.00	114.95	2.8
Хөрөнгө оруулалт	100.00	175.05	11.8
Хэрэглээ	100.00	137.16	6.5
Үйлчилгээний бус экспорт	100.00	94.48	-0.3
Үйлчилгээний бус импорт	100.00	147.96	8.1

Гадаад худалдааны нийт эргэлт (сая ам. доллар)

Хүснэгт №2

	1990	1995	2000
Нийт эргэлт	1584.7	888.6	1080.6
Экспорт	660.7	473.3	466.1
Импорт	924.0	415.3	614.5

Судалгаанаас үзэхэд 2000 онд нийт худалдааны эргэлт 1990 оныхоос 31.9 хувиар, экспорт 29.5 хувиар импорт 33.5 хувиар тус тус буурсан дүн харагдаж байгаа гадаад худалдааг өсөөгүй гэж үзэх боломж байгаа юм.

Бидний хийсэн судалгаанаас үзэхэд 1990 оноос хойшхи экспорт буурах хандлагад орсон байна. Нийт экспортод 2000 оны байдлаар зэс 34.4%, алт 1.3%, ноолуур 16.5%, махан бүтээгдэхүүн 3.4%-ийг бусад, эдгээр бүтээгдэхүүн л нийт экспортын 56%-ийг эзлэж байлаа. Монголын импорт тогтвортой нэмэгдэж түүний дотор машин, техник, нефтийн бүтээгдэхүүн зонхилж, хөгжиж буй орны импортын бүтцийн нийтлэг төрхийг илэрхийлж байлаа.

Судалгаанаас үзэхэд манай экспортын бүтэц бусад орныхоос ихээхэн ялгаатай ба машин тоног төхөөрөмж, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн бараг үгүй. Харин эзлэх хувийн жин багагүй буурсаар байгаа боловч хүнсний болон хүнсний биш түүхий эд экспортын гол бүтээгдэхүүн хэвээр үлдсээр байгаад Монголын экспортын хөгжлийн онцлог оршиж байна.

Бидний судалгаагаар тодорхойлогдсон 1990-2000 оны гадаад худалдааны өнөөгийн хөгжлийн төрхөд дараах үндсэн хүчин зүйлс нөлөөлжээ гэсэн дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Экспорт, импортын гол нэрийн бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дэх үнийн өөрчлөлт
2. Улс орны дотоодын нийт эрэлтийн өсөлт
3. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын нийт хэмжээ бүтэц
4. Валютын ханшийн өөрчлөлт

Шинэ зууны эхэнд улс орны гадаад худалдааны өсөлтөд эерэг нөлөөлөх хүчин зүйлс цөөнгүй байх ерөнхий хандлага ажиглагдаж байна.

Даяарчлал либералчлалын эрин зуунд Монгол улсын гадаад эдийн засгийн харилцаа, гадаад худалдааны хөгжлийн өсөлтийг хангах, үр ашгийг дээшлүүлэх бодит алхамуудыг маш оновчтой хийх нь өнөөгийн амьдралаас урган гарч буй чухал зорилт болж байна. Энэ зорилтыг хэргжүүлэхийн тулд гадаад худалдааны хөгжлийн тулгамдсан дараах асуудлууд зайлшгүй гарч ирж байгаа билээ. Үүнд:

- Экспортын үйлдвэрийг эрчимтэй хөгжүүлж бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх (технологи, стратегийн бүтээгдэхүүн, менежмент)
- Даяарчлалын үеийн дэлхийн зах зээлд гарах гадаад худалдааны гарцыг зөв тогтоох (бараа, технологи, оюуны бүтээгдэхүүн, үйлчилгээний экспорт)
- Үндэстний тэргүүлэх экспортлогч корпораци, пүүсийг засгийн газрын экспортын бодлогоор дэмжих
- Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг экспортын үйлдвэрлэлд оруулах эрх зүй, эдийн засгийн орчинг бүрдүүлэх
- Бүс нутгийн худалдаа, эдийн засгийн бүлэглэлд Монгол улсыг нэгтгэх стратеги, бодлогыг хэрэгжүүлэх /Ази Номхон Далайн Эдийн засгийн Комисс (АПЕК), Ази Номхон далайн Эдийн засаг, Нийгмийн хороо (ЭСКАП), Зүүн хойд Азийн орнуудын хамтын ажиллагааны "Түмэн бүс" хөтөлбөр гэх мэт/
- Худалдааны олон талт гэрээ хэлэлцээр байгуулах тогтолцоо болон бараа, үйлчилгээний олон улсын худалдааны зохицуулалтын иж бүрэн механизмыг бий болгох, зохистой ашиглах
- Монгол улсын худалдааны бодлого, "Монгол банк"-ны зээл, мөнгөний бодлогын уялдаа холбоог оновчтой тогтоох
- Гадаад худалдааны үр өгөөжийг хэрхэн дээшлүүлэх онол арга зүйн үзэл баримтлалыг боловсруулж, практикт хэрэгжүүлэх.